

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2022 ОНЫ 02 ДУГААР САРЫН 21-НИЙ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ЭЭЛЖИТ
/ЦАХИМ/ ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

2022 оны 03 дугаар сарын 03

Улаанбаатар хот

ДД	Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээг үй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Оноо
Үүрэг, даалгавар-НЭГ: 2022 оны төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг жигд ханган, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, бааз суурийг өргөтгөх чиглэлээр тодорхой ажил зохион байгуулж ажиллах.				
1.	Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн А/33 дугаар захирамжаар батлагдсан төсвийн орлогын хуваарийн дагуу 2022 оны 02 дугаар сард орлогын төлөвлөгөө 8 744 670,1 мянган төгрөг төвлөрөхөөс 6 633 577,34 төгрөг төвлөрч орлого гүйцэтгэлээр 75,9 хувьтай байна. 2022 оны 02 дугаар сарын 21-ны өдөр дүүргийн Засаг даргын А/65 тоот захирамжаар төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх талаар тодорхой ажил зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	70
Үүрэг, даалгавар ХОЁР: Нийслэлийн Засаг даргын 2022 оны "Хөрөнгө оруулалтын ажлыг эрчимжүүлэх тухай" А/212 дугаар захирамжийн хэрэгжилтийг заалт тус бүрээр сайтар хангаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.				
2.	<p>1.1 Нийслэлийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/140 дугаар захирамжаар дүүрэгт эрх шилжиж ирсэн нийт 3 ажил байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> Чандмань овооны тохижилт /14дүгээр хороо/- Зураг төсөл боловсруулах шатандаа Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил – 1 /ЧД/ – Газар чөлөөлөлт хийгдэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. <p>Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил – 2 /ЧД/ – Зураг төсөл боловсруулах шатандаа</p> <p>1.7 Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/140 дүгээр захирамжаар эрх шилжиж ирсэн 3 төсөл арга хэмжээ, дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих 13, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих 19, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас санхүүжих 5 төсөл, арга хэмжээ нийт 40 төсөл арга хэмжээ 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан. Үүнээс: Нийслэлийн Засаг даргаас эрх шилжиж ирсэн 3 төсөл арга хэмжээний үнэлгээний хороо байгуулагдсан, орон нутгийн төсвөөс хэрэгжих 10 төсөл арга хэмжээний тендер зарлагдсан байна. Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих 15 төсөл арга хэмжээний зураг төсөв 2022 оны 03 дугаар сарын 03-</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	30

	<p>ны өдөр захиалагчаас батлагдан ирсэн бөгөөд “Үнэлгээний хороо”-г дүүргийн Засаг даргын захирамжаар байгуулахаар ажиллаж байна.</p> <p>2. 2022 оны 02 дугаар сард орлогын төлөвлөгөө 8 744 670,1 мянган төгрөг төвлөрөхөөс 6 633 577,34 төгрөг төвлөрч орлого гүйцэтгэлээр 75,9 хувьтай байна.</p>			
Үүрэг, даалгавар ГУРАВ: 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн халдвартын тархалтын “Шар түвшин”-д шилжсэнтэй холбогдуулан “Коронавируст халдварт (Ковид-19)-ын тархалтын түвшинд үндэслэн хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах журам”-д заасныг баримтлан халдварт хамгааллын дэглэмийг сахиж, амны хаалт тогтмол зүүж, гарсаа ариутган, дархлаа сэргээх нэмэлт тунд ажилчдаа бүрэн хамруулж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг уриалж ажиллах.				
3.	<ul style="list-style-type: none"> - Дүүргийн хэмжээнд 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар “Коронавируст халдварт (Ковид-19)-аас сэргийлэх вакцинуулалтын I тунд - 109581 /96,3 хувь/, II тунд - 98618 /86.7 хувь/, III тунд - 48197 /49.3 хувь/, IV тунд - 6133 /6.3 хувь/-тай хамрагдсан байна. - Дүүргийн Цахим хуудас www.chingeltei.gov.mn Чингэлтэй дүүрэг / Chingeltei District фейсбүүк, гэсэн албан ёсны хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол “Коронавируст халдварт (Ковид-19)-аас сэргийлэх, дархлаа сэргээх нэмэлт тундаа идэвхтэй хамрагдах, шинжилгээний цэгийн байршлыг иргэдэд таниулан видео шторк болон постер хэлбэрээр иргэдэд сурталчлан ажиллаж байна. Фейсбүүк хаягт байршуулсан мэдээллийг тухай бүр шинэчлэн тайлант хугацаанд 26 удаагийн мэдээ оруулснаас 5684 хандалт авч нийт мэдээлэлд 19 эерэг сэтгэгдэл, 0 сөрөг сэтгэгдэл, 156 удаа таалагдаж, цахим хуудасны мэдээг 111 хуваалцсан байна. - Засаг даргын Тамгын газрын байранд өөрсдийн нөөц бололцоогоор өдөрт 3 удаа ариутгал халдвартгүйтгэл хийж, албан хаагчдыг халдварт хамгааллын дэглэмийг сахиж, амны хаалт тогтмол зүүж гарсаа ариутгахыг зөвлөж, шинж тэмдэг илэрсэн ажилтан албан хаагчдыг ажлын байранд нэвтрүүлэхгүйгээр түргэвчилсэн тестээр шинжилгээ авч эерэг гарсан тохиолдолд харьяа өрхийн эмнэлэг рүү цаг алдалгүй шилжүүлэн ажиллаж байна. Дархлаа сэргээх нэмэлт тунд 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар 6 албан хаагч хамрагдсан байна. 	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	90
Үүрэг, даалгавар ДӨРӨВ: Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдэд Коронавируст халдварт (Ковид-19)-аас сэргийлэх халдварт хамгааллын дэглэмийг чанд мөрдүүлж, цэцэрлэг, сургуулийн орчинд эцэг, эх, хүүхдүүдийн бөөгнөрөл үүсгэхгүй байхад анхаарч, хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллах.				
4.	<ul style="list-style-type: none"> - Дүүргийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/49 дугаартай “Хяналт шалгалаа хийх ажлын хэсэг байгуулах тухай” захирамжийн хүрээнд хамтарсан ажлын хэсэг томилогдон дүүргийн нийт 84 боловсролын байгууллагын сургалт үйл ажиллагааны бэлтгэл хангалт, халдвартгүйтгэл хийгдсэн байдал, цэвэрлэгээний болон халдвартгүйтгэлийн бодисын нөөц, хүнсний түүхий эд бүтээгдэхүүний аюулгүй байдал, цэцэрлэгийн хүүхдүүдийн эрүүл мэндийн шинжилгээнд хамрагдлалт, анги танхим, сургалтын орчны аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийн хангалаатыг газар дээр нь үзэж, мэргэжил арга зүйн зөвлөгөө, зааврыг өгч ажилласан. 	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	90

	<ul style="list-style-type: none"> - Сурагчдыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд эцэг эхчүүдийн оролцоо, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэн "School police"-г ажиллуулж мөн хүүхдүүдийн бөөгнөрөл үүсгэхгүй байхад анхаарч, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. - Сургууль, цэцэрлэгийн эмч, нийгмийн ажилтан, эцэг эхчүүдэд Коронавируст халдварт (Ковид-19)-аас сэргийлэх халдварт хамгааллын дэглэмийг чанд мөрдөх тухай цахим сургалтыг БШУЯ болон ЧДЭМН-тэй хамтран 2022 оны 02 дугаар сарын 24, 25-ны өдрүүдэд зохион байгуулсан. - Сургууль, цэцэрлэгийн багш, сурагчдын ирц, өвчлөл, вакцинжуулалтын мэдээг 7 хоног бүрийн Пүрэв гариг бүрт Нийслэлийн Боловсролын газарт өгөн ажиллаж байна. 			
Үүрэг, даалгавар ТАВ: Барилга угсралтын ажлын явцад гарч болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, барилгын норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулж, барилга угсралтын ажлын орчин тойрны өнгө үзэмжийг сэргээх.				
5.	<p>Чингэлтэй дүүрэгт барилга угсралтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй нийт 25 аж ахуйн нэгжид урьдчилан сэргийлэх хяналт тавихад үйл ажиллагаа зогссон-15, дотор засал явагдаж байгаа-6, гадна фасадын ажил гүйцэтгэж буй-4 ААНБ байна.</p> <p>Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын 2022.01.19-ний өдрийн 02-02/192 дугаар мэдэгдлийг барилга угсралтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 10 аж ахуйн нэгж байгууллагад хүргүүлж зөвлөө өгч ажилласан.</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	50
Үүрэг, даалгавар ЗУРГАА: Нийслэлийн нутаг дэвсгэрт байгаа далан суваг, борооны ус зайлзуулах шугам сүлжээний барилга байгууламж, гуу жалга нийтийн эдэлбэр газрын хог хаягдал, цас цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах.				
6.	<p>Чингэлтэй дүүргийн "Тохижилт үйлчилгээ" ХХК 7-16 дугаар хороо буюу 2 дугаар бүсэд 20 гаруй хүний бүрэлдэхүүнтэй 2 бүлэг, "Найши трейд" ХХК 3 дугаар бүс болох 17-19 дүгээр хороонд 13 хүний бүрэлдэхүүнтэй 2 бүлгийг тогтмол ажиллуулан хэвшээд байна.</p> <p>Дүүргийн гэр хорооллын 7-19 хороонд иргэдийн бүлгийн 30 гаруй хүний бүрэлдэхүүнтэйгээр 7 хоногт 2-3 удаагийн давтамжтайгаар түүвэр цэвэрлэгээг хийж гүйцэтгээд байна. Цэвэрлэгээний явцад гэр хорооллын гуу жалга, далан суваг, нийтийн эдэлбэр газрын үүсмэл хог хаягдал, шарилж болон лаг цэвэрлэгээг хийж нийт 7500 м² талбайн 85,0 тонн үүсмэл хог хаягдлыг ачилт хийн ажилласан.</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	100

ДАРГА

Н.БАТСҮМБЭРЭЛ

ТАНИЛЦСАН: НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

П.БАЯНБААТАР

ТАНИЛЦСАН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Н.ХАНГАЙ

ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

М.НАВЧАА

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Д.ДОЛГОРМАА